

Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/54 тоот тушаалаар батлагдсан заавар, журам, бүтцийн дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг нэгтгэн тайлагнаж байна. Үүнд:



Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2017 онд төрийн аудитын байгууллагын системийн хэмжээгээр дэвшүүлсэн “Эрх зүйн шинэчлэл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн, эхний хагас жилийн төлөвлөгөөт ажлуудыг бүрэн биелүүллээ.

Батлагдсан төсөв, орон тооны хүрээнд 12 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж, 2017 оны эхний хагас жилд 125 ажлын өдөр буюу 12000 хүн/цаг ажиллахаас санхүүгийн аудит болон бусад аудитын ачааллаас шалтгаалан дунджаар 63 хуанлийн өдөр буюу 504 хүн/цаг илүү ажилласан байна.

Тайлант хугацаанд Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 1 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудит болон 304 байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн бол аймгийн ИТХ-ын захиалга, өөрийн санаачлагаар тус бүр 2 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ.

2017 оны эхний хагас жилд хийгдсэн аудитуудаар нийт 20,808.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн, бүртгэл тайлагналтай холбоотой 6,545.8 сая төгрөгийн алдааг залруулж, 835.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 6,264.7 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага бичиж, 7,162.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөн, биелэлтэд хяналт тавин ажилласнаар 811.9 сая төгрөгийн акт, 4,834.9 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлээд байна.



2016 оноос шилжин ирсэн акт, албан шаардлагын дүнг нэгтгэн авч үзвэл, тайлант онд нийт 814,1 сая төгрөгийн акт, 5,931.3 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг ханган, актын биелэлт 96.6 хувьтай, албан шаардлагын биелэлт 80.5 хувьтай тайлагнагдлаа.



2017 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитуудын дүнд үндэслэн арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 38, бүртгэл тайлагналтай холбоотой 124, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 110, дотоод хяналтыг сайжруулах 55, бусад чиглэлээр 22 гэх мэтчилэн нийт 349 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсний 86.8 хувь нь биелэгдсэн дүн мэдээтэй тайлагнагдсан болно.

Холбогдох хууль, тогтоол, шийдвэр, стандартыг ханган ажиллаагүйгээс санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь их хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдэж, **“Хязгаарлалттай санал дүгнэлт”** авсан 3, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан 1, аудит хийлгэхээс үндэслэлгүйгээр татгалзаж, шаардсан баримт, материалыг гаргаж өгөөгүй 1, холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр сум хөгжүүлэх сангаас зээлийн гүйлгээ хийсэн 9 зэрэг нийт 14 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсээс 5-ийг нь бүрэн хангасан хариу ирүүлээд байгаа бөгөөд 9 нь хэрэгжих хугацаа болоогүй учир дараагийн улиралд шилжээд байна.

2017 оны эхний хагас жилд нийт 3,009.6 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн, харилцагчид хүлээн зөвшөөрснөөр төсвийн зардлын 1 төгрөгт ногдох үр өгөөж 28,5 төгрөгт хүрсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь хийж гүйцэтгэсэн аудитын дүн, илрүүлсэн алдаа зөрчил, өгсөн зөвлөмжийг хэрэглэгчдэд нээлттэй, ил тод мэдээлэх зарчмын хүрээнд аудитын тайлангууд, цаг үеийн ажлууд болон байгууллагын танилцуулга, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангуудыг AUDIT.MN цахим хуудсанд оруулаад байгаа бөгөөд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, холбогдох бусад үзүүлэлтүүдийг хуулийн хугацаанд нь SHILENDANS.GOV.MN нэгдсэн цахим хуудсанд мэдээлж ирлээ.

Аймгийн ИТХ-ын дарга, бүх гишүүдэд цахимаар, аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга, Хөгжлийн бодлогын болон СТС-гийн хэлтсийн дарга нар, аудит хийгдсэн байгууллагуудад аудитын тайланг хэвлэн хүргүүлж байна.

Сэлэнгийн мэдээ сонин, Миний монгол кабелийн телевиз зэрэг орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад аудитын тайланг бүрэн эхээр нь электрон шуудангаар тогтмол хүргүүлж ирлээ.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас холбогдох хууль¹, журмын² дагуу төрийн өмчийн 1, орон нутгийн өмчийн 10 аж ахуйн нэгж болон 3 МСҮТ, боловсрол,

¹ МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн 18.5 дахь заалт

² МУ-ын Ерөнхий аудиторын 2009 оны 108 тоот тушаалаар батлагдсан “Гэрээгээр аудит хийлгэх журам”

эрүүл мэндийн салбарын 66 байгууллага зэрэг нийт 80 байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийлгэхээр хараат бус аудитын 5 компанитай гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжүүлэн ажилласан болно.

Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар


Санхүүгийн тайлангийн аудитад нийт 304 байгууллага, аж ахуйн нэгжийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулахаар төлөвлөснөөс өөрийн аудитор, шинжээчдээр 224, хараат бус аудитын 5 компаниар 80 байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгүүллээ.

Үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан шалтгаанаар санхүүгийн тайлан гаргаагүй 2 ОНӨААН-ийн санхүүгийн тайланд аудит хийгээгүй болно.

Аудитад хамрагдсан 304 байгууллагын 19-д нь Ерөнхий аудиторын тушаалаар итгэл үзүүлж, 156 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 129 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргасан байна.

Нийт дүгнэлт гаргасан байгууллагын 126-д нь “Зөрчилгүй”, 3-д нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт өглөө.


Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,874.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 6,545.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 54,8 сая төгрөгийн төлбөрийн акт , 1,637.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 4,636.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.



Актын биелэлт: Өмнөх оны үлдэгдлээс 2.2 сая төгрөг, тайлант хугацаанд тогтоогдсон актаас 34,9 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт 63.4 хувьтай тайлагнагдсан бөгөөд 21,4 сая төгрөгийн актын төлбөр дараа улиралд шилжээд байна.

Албан шаардлагын биелэлт: Тайлант хугацаанд санхүүгийн аудитаар нийт 1,637.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн бөгөөд өмнөх оны албан шаардлагын үлдэгдлээс 103,8 сая төгрөгийн, тайлант хугацааны 1,428.2 сая төгрөгийн зөрчлийг арилгасан талаар харилцагч байгууллагуудаас хариу ирүүлж, албан шаардлагын биелэлт 87.9 хувьтай тайлагнагдлаа. 209.2 сая төгрөгийн албан шаардлагын биелэлт тооцох хугацаа хараахан болоогүй байна.

График №5



Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өгч хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.

Зөвлөмжийн хэрэгжилт: Аудитаар арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 20, бүртгэл тайлагналтай холбоотой 111, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 94, дотоод хяналтыг сайжруулах 30, бусад 15 зэрэг нийт 270 зөвлөмж өгснөөс 254 зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай хариу ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 94.0 хувьтай байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 78.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож харилцагчаар хүлээн зөвшөөрүүлсэн ба. Өөрийн аудитор, шинжээчдийн хийж, гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын бүх үе шатны ажлыг СТАУС программаар гүйцэтгэсэн болно.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

Тайлант онд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 1, аймгийн ИТХ-ын захиалгаар 2, өөрийн санаачлагаар 1 зэрэг нийт 5 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр:

- “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Засгийн газраас олгосон векселийн үр дүн”

2. Аймгийн ИТХ-ын захиалгаар:

- “Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны үр дүн”
- “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”

3. Өөрийн санаачлагаар:

- “Аймаг хөгжүүлэх сангаас олгосон зээл, түүний эргэн төлөлт, зарцуулалтын үр дүн, үр нөлөөт байдал”
- “Сүхбаатар сумын 12 жилийн бүрэн дунд сургуулиудын үйл ажиллагааны үр дүн”

5 гүйцэтгэлийн аудитын дүнг нэгтгэн авч үзвэл:

Актын биелэлт: Өмнөх оны үлдэгдэл 3,3 сая төгрөг, тайлант оны 759,8 сая төгрөг зэрэг нийт 763,1 сая төгрөгийн актаас 756.1 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт 99.0 хувьтай тайлагнагдсан бөгөөд 7,0 сая төгрөгийн актын төлбөр дараа улиралд шилжээд байна.

Албан шаардлагын биелэлт: Урьд оноос шилжиж ирсэн 625.0 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант хугацаанд өгөгдсөн 3,500.6 сая төгрөгийн албан шаардлагаас 2,292.2 сая төгрөгийн зөрчлийг арилгасан талаар харилцагч байгууллагуудаас хариу ирүүлж, 1208,4 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжүүлэх хугацаа болоогүй учир дараа улиралд шилжээд байна. Ингэснээр албан шаардлагын биелэлт 83.3 хувьтай тайлагнагдлаа.

Зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оны үлдэгдэл 8, тайлант оны 65 зэрэг нийт 73 зөвлөмжөөс 61,6 хувь буюу 45 зөвлөмжийг хэрэгжүүлсэн бөгөөд үлдэгдэл 28 зөвлөмжийн хэрэгжүүлэх хугацаа болоогүйгээс дараа улиралд шилжээд байна.

График №7



Гүйцэтгэлийн аудитаар 2,621.3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 9 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн нь хэрэгжүүлэх хугацаа болоогүй учир дараа улиралд шилсэн болно.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар


Тайлант хугацаанд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 1 нийцлийн аудит хийж гүйцэтгэв. Үүнд:

- “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт”

Актын биелэлт: Өмнөх оноос шилжсэн актын үлдэгдэл байхгүй ба тайлант хугацаанд тогтоосон 20,9 сая төгрөгийн актыг бүрэн барагдуулаад байна.

Албан шаардлагын биелэлт: Өмнөх оноос шилжиж ирсэн албан шаардлагын үлдэгдэл 367,6 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, тайлант хугацаанд өгсөн 1,126.7 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлагын 1,114.5 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авсан талаар харилцагч байгууллагуудаас хариу ирүүлснээр албан шаардлагын биелэлт 98.8 хувьтай тайлагнагдлаа.

График №6



Зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оноос шилжиж ирсэн 7 зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант онд 14 зөвлөмж өгсний 85.6 хувийг буюу 12 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Нийцлийн аудитаар 309,7 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагчаар хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд Төрийн аудитын тухай хуулийн 28-р зүйлийн дагуу 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өгснийг 100 хувь биелүүлж, сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Тав. Аймгийн ИТХ-ын хүсэлтээр хийсэн аудит болон ИТХ-тай хамтран ажилласан талаар

Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн бүх / гүйцэтгэлийн 5, нийцлийн 1 / аудитын тайлан, дүнг аймгийн ИТХ-д хүргүүлж хэвшсэн бөгөөд аймгийн ИТХ-ын захиалгаар дараах гүйцэтгэлийн аудитуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- “Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны үр дүн”
- “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”

Эдгээр аудитуудаар нийт 3,2 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.208,4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага бичигдэж, 28 зүйлийн зөвлөмж өгсөн нь хэрэгжих хугацаа болоогүй учир дараа улиралд шилжсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд ” Сэлэнгэ аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан, дүн “-г аймгийн ИТХ-ын нэгдсэн хуралдаанд оруулж, хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

Зургаа. Дотоод ажлын талаар

2017 оны эхний хагас жилд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 11 тушаал гарч, явсан бичиг 127, албан тоотоор ирсэн бичиг 35, цахимаар ирсэн бичиг 43 тус тус бүртгэгджээ.

Аудитор, шинжээчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд авч, тайлан, мэдээг хүргүүлсэн бөгөөд аудит хийж гүйцэтгэх тухай бүр ашиг, сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг ажилтнуудаар гаргаж, баталгаажуулж байна.

МУ-ын Ерөнхий аудиторовын 2017 оны 04-р сарын 07-ний өдрийн А/59 дугаар тушаалын дагуу байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тамга тэмдэг, хэвлэмэл хуудсуудыг шинээр хийлгэж, ашиглаж байгаа ба долоо хоногт хийж гүйцэтгэсэн ажлын тайланг баасан гариг бүр гаргаж, ҮАГ-т мэдээлж байна.

Нэгдсэн хөтөлбөрийн дагуу хийгдэх аудит болон бүтэц зохион байгуулалт, хууль, эрхийн актуудын шинэчлэл, өөрчлөлттэй холбоотойгоор 13 судалгаа, санал хүсэлт, төрийн одон медаль, салбарын “ Тэргүүний ажилтан”-аар шагнуулахаар 3 ажилтны тодорхойлолтыг тус тус ҮАГ-т хүргүүлэв.

Сургалт, зөвлөгөөн :

ҮАГ-аас зохион байгуулсан: Дархан-уул аймагт зохион байгуулсан СТАУС программын сургалтад бүх аудитор, шинжээчид,



- Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, сургалтад дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа, аудитын менежер Б.Батмөнх нар тус тус оролцсон болно.

Дотоод сургалт: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас холбогдох байгууллагуудад хүсэлт тавьж, зохион байгуулсан дараахь сургалтуудад бүх аудитор, шинжээчдийг хамруулсан байна. Үүнд:

- “Албан бичиг баримтын хадгалалт, хамгаалалт, стандарт” сэдвээр хийсэн сургалт,



- “Хүний эрхийн үндсэн ойлголт” сэдэвт сургалт,



Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт: Дараах сургалтуудад холбогдох аудитор, шинжээчдийг хамруулав. Үүнд:

- 05-р сард ММНБИ-ээс зохион байгуулсан “Аудиторын сургалт”-д ахлах аудитор



Б.Наранчимэг хамрагдаж “Аудиторын батламж” авлаа.

- МНБ-ийн эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтад шинжээч А.Дашбат, Э.Эрдэнэзул, Ж.Цогт, Ц.Уртнасан нар хамрагдан, шалгалт өгч 2-4 хичээлийн хөнгөлөлт авсан байна.
- Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан “ХАСУМ, ХАСХОМ гаргах эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал” сэдэвт онлайн сургалтад ЭБАТ аудитор Ц.Отгонбаяр нар тус тус хамрагдав.

Албан харилцаа

- Төр, төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын дүнг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудын удирдах болон бүртгэлийн ажилтнуудад танилцуулж, цаашид анхаарах асуудлын талаар аудитын менежер Б.Батмөнх мэдээлэл өгөв.
- Гүйцэтгэж байгаа аудитын талаар ҮАГ-ын холбогдох албан тушаалтнуудаас тухай бүр зааварчилга авснаас гадна зохион байгуулж буй цахим хуралд бүрэн оролцож аудитын явц, үр дүнгийн талаар мэдээлэл хийж ирлээ.
- Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан олон нийтийг хамарсан мод тарих, субботник хийх ажлуудад хамт олноороо идэвхитэй оролцов.



Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн Цагааннуур сумын иргэн Н.Отгонсансарын өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариу өгөв.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд 111,0 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр 105,5 сая төгрөг зарцуулан, 5.5 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдлаа.

Нийт зардлын гүйцэтгэлийн 89.7 хувийг цалин, НДШ-ийн зардал, 10.3 хувийг бараа үйлчилгээний урсгал зардал эзэлж байна.

МУ-ын Ерөнхий аудиторовн 2017 оны 05-р сарын 30-ны өдрийн 1023 тоот “Эд хөрөнгийн тооллого явуулж, санал ирүүлэх тухай” албан бичиг, байгууллагын 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулж дарга, тэргүүлэх аудиторовн 2017 оны А/07 дугаар тушаалаар томилогдсон “Эд хөрөнгийн тооллогын комисс” хөрөнгийн тооллого явуулж, эзэмшүүлэх картыг шинэчлэн хөтлөв. Мөн эд хөрөнгийн тооллогын бүртгэл, хөрөнгийн хөдлөлийн тайлан, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл зэргийг УАГ-т заасан хугацаанд явуулсан болно.

Төсвийн гүйцэтгэл, НДШ-ийн болон татварын тайлангуудыг хуулийн хугацаанд нь гарган холбогдох байгууллагуудад хүргүүлж байсан бөгөөд 2016 оны жилийн эцсийн болон 2017 оны 1-р улирлын санхүүгийн тайлан, 2018 оны төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдлүүдийг тогтоосон хугацаанд нь УАГ-т хүргүүлэв.

Наймдугаар бүлэг. Дүгнэлт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь төрийн аудитын байгууллагын системийн хэмжээд тодорхойлсон **“Эрх зүйн шинэчлэл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх”** зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн явуулж, 2017 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

ТАЙЛАН БИЧСЭН:

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА